



ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН
ИХ СУРГУУЛЬ

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 он 01 сар 27 өдөр

Дугаар А/06.

Улаанбаатар хот

Олон улсын Улаанбаатарын их сургуулийн багш,
ажилтны ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах тухай

Тус сургуулийн Захиргааны зөвлөлийн 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн
хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "ОУУБИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм"-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. "ОУУБИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм"-ийг нийт багш, ажилтанд танилцуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг бүрэлдэхүүн сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч, алба, хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус сургуулийн Ерөнхий захирлын 2016 оны 1 дүгээр сарын 12-ны А/02 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



ЧОЙ ГИ ХО

ОУУБИС-ийн ерөнхий захирлын
2021 оны 01 дугаар сарын 29 өдрийн
А/О.Б. дугаар тушаалын хавсралт



ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН БАГШ, АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Багш, ажилтны ёс зүйн дүрмийн зорилго

Олон улсын Улаанбаатарын их сургуулийн (цаашид "ОУУБИС" гэнэ) багш, ажилтны мөрдөх ёс зүйн зарчим, хэм хэмжээг тогтоон, хэвшүүлж сахиулах, ёс зүйн зөрчлийн тухай мэдээлэл, гомдол гаргах, түүнийг хүлээн авах, шалган шийдвэрлэх, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх, багш, ажилтны ёс зүйн харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээг тогтооход дүрмийн зорилго оршино.

1.2. Багш, ажилтны эрхэмлэх зүйлс

1.2.1. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, эрдэм мэдлэгийг дээдлэх, үнэнч, шударга, зарчимч байдал, ёс журмыг сахин биелүүлэх нь ОУУБИС-ийн багш, ажилтан, удирдах зөвлөлийн гишүүн бүрийн эрхэмлэх үнэт зүйл мөн.

1.2.2. ОУУБИС-ийн багш, ажилтан нь суралцах, багшлах, эрдэм шинжилгээний ажлын эрх чөлөө, мэргэжлийн үнэ цэнийг хамгаалахын зэрэгцээ нийгмийн хариуцлагыг ухамсарлан, хүн бүрд чанартай, бүтээмжтэй, үр нөлөөтэй ажиллах, суралцах тэгш боломж олгохыг эрмэлзэнэ.

1.2.3. Мэргэжлээрээ гарамгай байж, ажиллах, суралцах үүргээ хариуцлагатай гүйцэтгэхийн зэрэгцээ нийгэм, хамт олон, оюутанд чин сэтгэлээр хандан, аливаа шударга бус, ёс бус үйлдэл гаргахгүй байхыг эрмэлзэнэ.

1.3. Дүрмийн үйлчлэх хүрээ

1.3.1. ОУУБИС-ийн багш, ажилтан бүр энэхүү ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

1.3.2. Дүрэм нь ОУУБИС-аас зохион байгуулж буй ажил, үйл ажиллагааны явцад хэрэгжинэ.

1.4. Дүрмийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

1.4.1. ОУУБИС-ийн багш, ажилтан дүрмийг чанд сахин биелүүлж, ёс зүйн зөрчил гаргахгүй байх үүрэгтэй.

1.4.2. Дүрмийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйд хариуцлага тооцохдоо ОУУБИС-ийн хамт олны эвсэг хамтын ажиллагааг хамгаалж, багш, ажилтны ёс зүйг дээшлүүлэх бодлого баримтална.

1.4.3. Ёс зүйн дүрмийн зөрчлийг шийдвэрлэхдээ оролцогч талуудын эрх, тэгш байдлыг хангаж, хүсэлт тайлбараа гаргах эрх, нөгөө талын байр суурийг сонсох үүрэгтэй.

1.5.Нэр томьёоны тодорхойлолт

1.5.1.“Дүрэм” гэж энэхүү ОУУБИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрмийг

1.5.2.“багш” гэж их сургуулийн профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн зэрэглэлтэй багшийг

1.5.3.“удирдах ажилтан” гэж бүх шатны шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан, тухайлбал, ОУУБИС-ийн захирал, дэд захирал, бүрэлдэхүүний сургуулийн захирал, бүрэн дунд сургуулийн захирал, сургалтын албаны дарга, тэнхим, лаборатори, төвийн эрхлэгч, захиргаа, санхүү, аж ахуйн асуудал хариуцсан нэгжийн удирдах ажилтныг

1.5.4. “ажилтан” гэж ОУУБИС-ийн захиргааны болон санхүү нягтлах бодох бүртгэлийн алба, эрдэм шинжилгээ, гадаад харилцаа, хангамж үйлчилгээний хэлтэс, төвүүд, бүх шатны сургалтын алба, номын сан, оюутны бие даан суралцах төв, тэнхим, лабораторийн ажилтан, туслах ажилтан, ажилчныг

1.5.5.“зөрчил” гэж дүрэмд заасан багш, ажилтны ёс зүйн хэм хэмжээ болон хориглосон заалтыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг

1.5.6.“гомдол” гэж зөрчлийн улмаас хохирсон гэж үзэж иргэн эсвэл түүний төлөөллийн эрх бүхий этгээдэд зохих журмаар хандаж, уг хохирлыг арилгуулахаар гаргасан хүсэлтийг

1.5.7.“гомдол шийдвэрлэх ажиллагаа” гэж гомдлыг шалгаж, эцэслэн шийдвэрлэхээр Их сургуулийн ерөнхий захиралд дүгнэлт, саналаа танилцуулан аливаа шийдвэр гарах үе хүртэлх ажиллагааг

1.5.9“ёс зүйн хэм хэмжээ” гэж багшийн мэргэжилдээ үнэнч байж, мэргэжлийн нэр хүндийг хамгаалах, хүлээсэн үүргээ чанд биелүүлэх талаар тогтоосон шаардлагын цогцыг

1.5.10.“суралцагч” гэж зохих журмын дагуу элсэлтийн шалгалт өгч, ерөнхий захирлын тушаалаар элссэн оюутан, магистрант, докторантыг ойлгоно.

Хоёр. ОУУБИС-ийн багш, ажилтны дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ

2.1. Нийтлэг дагаж мөрдөх хэм хэмжээ

ОУУБИС-ийн гишүүний дагаж мөрдвөл зохих доорх ерөнхий хэм хэмжээ нь ОУУБИС-ийн багш, ажилтан бүрд тэгш үйлчлэхийн зэрэгцээ тэдний ажил үүргийн онцлогийг тусгасан тусгай хэм хэмжээгээр давхар баталгаажна. Үүнд:

Үүрэг болгосон хэм хэмжээ

- 2.1.1. Үнэнч, шударга зарчимч, хариуцлагатай, эрдмийн чин шударга байдлыг эрхэмлэн бүтээлчээр хамтран ажиллах
- 2.1.2. Ажлын байранд биеэ зөв авч явах, орчин тойрныхоо хүмүүст зүй ёсны шаардлага тавьж, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангахад хувь нэмрээ оруулах
- 2.1.3. Иргэний харьяалал, яс үндэс, нас, хүйс, шашин шүтлэг, оюуны чадавх, үзэл бодол байр суурь, гадаад үзэмж, хөрөнгө чинээ, нийгмийн гарал байдал, гэр бүлийн байдал, төгссөн сургууль, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлага зэрэг аливаа шинжээр ялгаварлахгүй тэгш хандах
- 2.1.4. Ажил хэрэгт хувийн харилцаа болон хүмүүсийн хоорондын харилцаанд сөрөг харьцаанаас ангид ажиллах
- 2.1.5. Оногдсон үүрэг даалгаврыг чанартай биелүүлэх
- 2.1.6. Шийдвэрийг бодитой, үндэслэлтэй гаргаж, ил тод байлгах
- 2.1.7. Суралцах эрүүл, аюулгүй орчинд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдлаас сэргийлж, шаардлагатай хүчин чармайлт гаргах.

Хориглосон хэм хэмжээ

- 2.1.8. Санаатай, хайхрамжгүй, хэтэрхий болгоомжгүй, хариуцлагагүй үйлдэл, эс үйлдэхүйгээр бусдын аюулгүй байдал, бие, сэтгэцийн эрүүл мэнд, амь насанд шууд аюул занал учруулах
- 2.1.9. Санаатай, хайхрамжгүй, хэтэрхий болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр бусдын аюулгүй байдал, бие, сэтгэцийн эрүүл мэнд, амь насанд аюул занал учруулж болзошгүй байдал үүсгэж, айдаст автуулах
- 2.1.10. Бусдын биед хүсэл, зөвшөөрлийг үл харгалзан бэлгийн сонирхлоор халдах, бэлгийн сонирхлоо илэрхийлэх, бусдыг өөрийн бэлгийн эрхшээлд оруулах буюу хүч түрэмгийлэн дарангуйлах (биеийг нь үнэлүүлэх, дүрс, дууны бичлэгт оруулах, бэлгийн замын өвчин санаатай халдаах), бэлгийн дарамт үзүүлэх, биеийн нууцлаг хэсгийг ил гаргах, насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох
- 2.1.11. Сургууль, бусдын эд хөрөнгийг санаатай, хайхрамжгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр устгах, эвдэж гэмтээх эсхүл завдах

- 2.1.12. Сургууль, бусдын эд хөрөнгийг хулгайлах, дур мэдэн ашиглах, эзэмшилдээ авах, зориулалтын бусаар ашиглах, шамшигдуулах
- 2.1.13. Сургуулийн анги танхим, албан тасалгаа, лаборатори, дотуур байр, номын сан, оюутны бие даан суралцах төв, биеийн тамирын заал, хоолны газар, бие засах газар, коридор зэрэг газар (цаашид "Сургуулийн орчин" гэх)-т согтууруулах ундааны зүйл хэрэглэх, согтуурч зохисгүй зан авир гаргах;
- 2.1.14. Мэргэжлийн эсвэл хуулийн зайлшгүй шаардлага гарснаас бусад тохиолдолд мэргэжлийн үйл ажиллагааны явцад олж авсан бусдын хувийн нууцтай холбоотой мэдээллийг задруулах
- 2.1.15. Бусдын хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцох, хувь хүнийх нь талаар сөрөг үнэлэлт, дүгнэлт гаргах, тараах
- 2.1.16. Бусдыг үл хүндэтгэх, бүдүүлэг авирлах, үг хэлээр дайрч доромжлох, айлган сүрдүүлэх, дарамтлах
- 2.1.17. Өөрийн үзэл бодол, байр суурийг зөвтгөхийн төлөө бусдын үзэл бодол, байр суурийг мушгин гуйвуулах, гутаан доромжлох
- 2.1.18. Сургуулийн орчинд ил задгай, зохисгүй хувцаслах
- 2.1.19. Албан үүрэгтэйгээ холбогдуулан бусдаас бэлэг сэлт, шан харамж авах, өгөх
- 2.1.20. Ажил үүрэг, эрх мэдлийн хүрээнд аливаа шийдвэр, үйлдэлд нөлөөлж болохуйц талархал, бэлэг, шан харамж, ашгийг материаллаг ба материаллаг бус байдлаар авах, авахыг хүсэх, шаардах, үүний улмаас хэн нэгэнд хариу барих нөхцөл байдал үүсгэх
- 2.1.21. Багш, ажилтны ажил байдлын үнэлгээ, аттестатчиллын дүн, суралцагчдын сурлагын дүн, санал асуулгын үр дүнд нөлөөлөх аливаа үйлдэл хийх

2.2. Багшийн дагаж мөрдөх хэм хэмжээ

А. Мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ

а) Сургалтын ажлын хүрээнд

Сургалтын орчныг боловсронгуй болгон, нийгэм дэх боловсролын үнэлэмжийг өндөрт өргөхөд хувь нэмрээ оруулах явдал багш, эрдэм шинжилгээний ажилтны эрхэм үүрэг, хариуцлага мөн бөгөөд сургах эрх чөлөөг хамгаалах, багш, ажилтан, суралцагчдын сурч боловсрох тэгш боломжийг баталгаажуулах, бүтээлч байх нь ОУУБИС-ийн багшийн сургалтын хүрээнд баримтлах тулгуур зарчим мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- 2.2.1. Хичээлийн хөтөлбөрийг баримтлан хичээл, сургалтаа мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах
- 2.2.2. Мэдлэг чадвар, заах арга барилаа байнга дээшлүүлж, өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллах
- 2.2.3. Хичээлийн агуулгыг орчин үеийн нийгмийн болон салбар ухааны хөгжлийн шаардлага, чиг хандлагатай нийцүүлэн шинэчилж байх
- 2.2.4. Хичээлийн хуваарь, цагийг баримталж хичээлийн цагийг үр өгөөж, идэвхтэй өнгөрүүлэх
- 2.2.5. Суралцагчийн хүмүүжил, төлөвшилд анхаарч, эрдэм мэдлэг, оюуны чадамж, бүтээлч чанараараа үлгэрлэх
- 2.2.6. Суралцагчтай ажиллах, зөвлөгөө өгөх хуваарийг баримтлах
- 2.2.7. Суралцагчдад хичээл, сургалттай холбогдолтой мэдээ, мэдээлэл олж авах боломж бүрдүүлэх
- 2.2.8. Суралцагчийн эрдэм номд хандах идэвх санаачилгыг өрнүүлэх, бие даан суралцах чадвар эзэмшүүлэх, бүтээлч, шүүмжлэлт, логик сэтгэлгээг хөгжүүлэх
- 2.2.9. Суралцагчийн мэдлэг, чадварыг шалгах хэлбэр, шалгалтын агуулгын хүрээ, үнэлэх шалгуурыг ил тод, тодорхой байлгах
- 2.2.10. Суралцагчийн даалгаврыг цаг тухайд нь шалгаж, үр дүнг мэдээлж байх;
- 2.2.11. Суралцагчийг шалгах, дүгнэх, үнэлэх, ажил удирдах, тодорхойлолт бичихдээ тэгш, шударга, бодитой хандах
- 2.2.12. Суралцагчийн бие даан гүйцэтгэх ажил нь оюутны боломж, хөтөлбөрийн түвшинд нийцсэн байж, тухайн ажлын чиглэл, агуулга, ашиглах мэдээллийн эх сурвалжийг тодорхой байлгах

Хориглосон хэм хэмжээ

- 2.2.13. Хичээл таслах, хичээлээс хоцрох, эрт тараах, хичээлийн цагаар танхимыг орхих
- 2.2.14. Сургуулиас санаачилсан, ивээн тэтгэсэн ажил, үйлчилгээг таслах, тасалдуулах
- 2.2.15. Сургуулийн багш нарыг үүрэг ажлаа гүйцэтгэхэд нь саад учруулах
- 2.2.16. Дүнг бодитой бус, хуурамчаар тавих, суралцагчийн мэдлэг чадвар, хандлагыг тухайн хичээлд шууд хамааралгүй шалгуураар дүгнэх
- 2.2.17. Зохих журмаар батлагдсан хичээлийн хөтөлбөр, бусдын судалгааны чиглэлийг үгүйсгэж тэдгээрт итгэх суралцагчийн итгэлийг хөсөрдүүлэх

- 2.2.18. Суралцагчдад бие даан сурах хэрэглэгдэхүүн, хичээлийн гарын авлага, ном сурах бичиг тулган борлуулах
- 2.2.19. Суралцагчийн сурлагад ахиц гарахад саад болох.
- 2.2.20. Шалгалтын материалыг зориудаар болон санамсаргүйгээр задлан тараах

б) Судалгааны ажлын хүрээнд

Эрдэм судлалын ажлын тогтсон хэм хэмжээг баримталж мэдлэг олж авах, шинэ мэдлэг бүтээх, судалгаа эрдэм шинжилгээний ажлыг эрхэмлэх, шинжлэх ухааны хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах нь багш, эрдэм шинжилгээний ажилтны судалгааны ажлын хүрээнд баримтлах тулгуур зарчим мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- 2.2.21. Судалгаа шинжилгээний арга зүй, мэдлэг, чадвараа байнга дээшлүүлэх
- 2.2.22. Бусад багш, судлаачийн эрдмийн эрх чөлөөг хүндэтгэх
- 2.2.23. ОУУБИС-ийн нэрээр аливаа төсөлт ажил удирдах, оролцох тохиолдолд энэ талаар тодорхой мэдээлж тайлагнах
- 2.2.24. Судалгаа эрдэм шинжилгээний ажилд залуу багш, судлаач, суралцагчдын оролцоог дэмжих
- 2.2.25. Өөр үзэл бодол, байр суурь, арга хандлагыг хүлцэх

Хориглосон хэм хэмжээ

- 2.2.26. Бусдын бүтээл, санааг хулгайлах, ишлэлгүй ашиглах, хуулбарлах, зохиогчийн зөвшөөрөлгүй ашиглах
- 2.2.27. Бусдын бүтээлийг өөрийн болгож илэрхийлэх, хамтын бүтээлийг дангаар хийсэн мэт илэрхийлэх
- 2.2.28. Судалгаанд хамтарч оролцсон эрдэм шинжилгээний ажилтан, суралцагчид, туслах ажилтны эрх ашиг, нэр төрийг сэвтээх, оролцооны хувь нэмрийг шударга бус үнэлэх
- 2.2.29. Судалгааны үр дүнг дөвийлгөх, үнэн байдлыг гуйвуулах, зохиомлоор тайлагнах
- 2.2.30. Эрдэм шинжилгээний гэрээт болон төсөлт ажилд судлаачийн зөвшөөрлийг үл харгалзан оролцуулах
- 2.2.31. Сургуулийн болон тухайн судлаачийн нэрийг зөвшөөрөлгүй ашиглах;

в) Нийгэмд үйлчлэх хүрээнд

Мэдлэг чадвараараа нийгэмд хувь нэмрээ оруулан нийгэмд манлайлах, үлгэр дуурайл үзүүлэх, багшийн нэр хүндийг өндөрт өргөх нь багшийн нийгэмд үйлчлэх хүрээнд баримтлах тулгуур зарчим мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- 2.2.32. ОУУБИС-ийн багшийн нийгмийн хариуцлагыг ухамсарлах, тэдгээрийг бүрэн хүлээн зөвшөөрч, дэмжих
- 2.2.33. Улс, нийгмийн өмнө тулгарч буй асуудалд алсын хараатай, бүтээлч, шүүмжлэлт байр сууринаас хандаж, мэргэжлийн үүднээс ажил хэрэгч санал дэвшүүлэх
- 2.2.34. Мэргэжил мэдлэг, судалгааныхаа үр дүнг нийтэд зарлах, түгээх, нэвтрүүлэхдээ хүнлэг байж, нийтийн эрх ашигт нийцүүлэх
- 2.2.35. Нийгэмд хүргэж буй мэдээлэл нь шударга, бодитой, үндэслэлтэй байх
- 2.2.36. Мэргэжлийн шүүмж өгөх, шүүмж хүлээн авах

Б. Харилцааны ёс зүйн хэм хэмжээ

а) Суралцагчтай харилцах

Суралцагчийн эрх ашгийг дээдэлж, танин мэдэх чөлөөт эрмэлзлийг дэмжин хөгжүүлж, харилцан хүндэтгэлтэй, тэгш, шударга, бодитой хандах, харилцан итгэл хүлээсэн байх нь ОУУБИС-ийн багш, суралцагч хоорондын харилцааны тулгуур зарчим мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- 2.2.37. Суралцагч санаа бодлоо чөлөөтэй солилцох уур амьсгал бүрдүүлэх
- 2.2.38. Суралцагчийн эрдэм мэдлэгт хандах идэвх санаачилгыг өрнүүлж, оюуны эрэл хайгуулд хамтдаа зүтгэгч хэмээн хүндэтгэж харьцах
- 2.2.39. Суралцагчийг харилцааны өндөр соёлтой иргэн болж төлөвшихөд нь туслах, биеэр үлгэрлэх

Хориглосон хэм хэмжээ

- 2.2.40. Хувийн ашиг сонирхолд нийцүүлэн суралцагчийн хөдөлмөрийг ашиглах
- 2.2.41. Мэргэжлийн эсвэл хуулийн зайлшгүй шаардлага гарснаас бусад тохиолдолд мэргэжлийн үйл ажиллагааны явцад олж авсан суралцагчийн талаарх мэдээллийг бусдад задруулах
- 2.2.42. Суралцагчийг хүйсээр болон бусад байдлаар ялгаварласан, ичээн зовоож, гутаан доромжилсон үг хэлэх, үйлдэл хийх
- 2.2.43. Суралцагчид бэлгийн дарамт үзүүлэх, бэлгийн харьцаанд орох
- 2.2.44. Багшийн байр суурийн давуу байдлыг ашиглан суралцагчид аливаа дарамт, шахалт үзүүлэх

б) Хамт олонтой харилцах

Харилцан тэгш, хүндэтгэлтэй, итгэл хүлээсэн, хүнлэг байх, харилцааны өндөр соёлтой, аливаа санал өгөх, шийдвэр гаргахдаа ухаалаг, үндэслэлтэй байж зүйд

нийцүүлэх, асуудалд ил тод, нээлттэй, шударга, бодитой хандах нь ОУУБИС-ийн багш, хамт олны харилцааны тулгуур зарчим мөн.

Үүрэг болгосон хэм хэмжээ

- 2.2.45. Бусадтай ялгаварлалгүй, хүндэтгэлтэй харилцах
- 2.2.46. Бусдын ажил, бүтээлд мэргэжлийн үүднээс шударга, бодит үнэлгээ, шүүмж өгөх
- 2.2.47. Багаар ажиллахдаа цаг барьж, цахим хуудас, захиагаа тогтмол шалгах
- 2.2.48. Багаар ажиллахдаа урьд өмнө үүссэн үзэл бодлын ялгаа, зөрүүтэй байдал, одоогийн ажилд үл хамаарах маргаан, санал нийлээгүй үр дүнгээс ангид байх

Хориглосон хэм хэмжээ

- 2.2.49. Санал өгөх, шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын зөрчил гаргах
- 2.2.50. Байр суурийн давуу байдлаа ашиглах
- 2.2.51. Бусдын ажил, бүтээлийг дүгнэхдээ мэргэжлийн бус шалгуураар хандах, мэргэжлийн ур чадварыг нь буруу илэрхийлэх, дутуу үнэлэх
- 2.2.52. Мэргэжил, мэргэшлийн мэдлэг чадвартай холбоотой материалаа нуун дарагдуулах, худал мэдүүлэг хийх
- 2.2.53. Ажил мэргэжилд өрсөлдөж байгаа хүний мэдлэг, чадварын талаар санаатай худал мэдүүлэг гаргах
- 2.2.54. Багшлах эрхгүй хүний багшлах хууль бус үйлдэлд нь туслах

2.3. Удирдах ажилтан болон бусад ажилтны дагаж мөрдөх хэм хэмжээ

А. Ажил үүрэгтэй холбоотой хэм хэмжээ

а) Нийтлэг хэм хэмжээ

Үүрэг болгосон хэм хэмжээ

- 2.3.1. Үүрэгт ажлаа хариуцлагатай, идэвх санаачилгатай гүйцэтгэх
- 2.3.2. Ажлын цаг баримталж, үр өгөөжтэй, бүтээлч ашиглах
- 2.3.3. Мэдээллийг нээлттэй, ил тод, тогтмол байлгаж, шаардлагатай, хүссэн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх;
- 2.3.4. ОУУБИС-ийн багш, ажилтан болон тэдний төлөөллөөс тавьж буй шүүмжлэл, шаардлага, өргөдөл, гомдлыг бодит үндэслэлтэй, тэгш, шударга шийдвэрлэх.

Хориглосон хэм хэмжээ

- 2.3.5. Хувийн ашиг сонирхлын үүднээс сургуулийн бизнесийн үйл ажиллагаанд ямарваа нэг санал тавих, мэдээлэл, сурталчилгаа хийх, зөвшөөрөл олгох, шийдвэр гаргах

- 2.3.6. Үүрэгт ажлаа хувийн ашиг сонирхолтой хольж хутгах, эсвэл бусдад тийм хардлага төрүүлэх нөхцөл байдал үүсгэх
- 2.3.7. Боловсон хүчнийг ажилд авах, албан тушаалд дэвшүүлэх, ажилд томилох, шагнал урамшуулалд тодорхойлох, мэргэжил дээшлүүлэхэд ашиг сонирхлын зөрчил гаргах, ил тод байдлыг үл хангах
- 2.3.8. Эрх мэдлээ урвуулан ашиглаж ойр дотно харьцаатай хүмүүст давуу боломж олгох, дэмжлэг үзүүлэх
- 2.3.9. Урьдчилан зохих зөвшөөрөл авалгүйгээр сургуулийн нэр ашиглан бараа бүтээгдэхүүний реклам, сурталчилгаа хийх
- 2.3.10. Ажлын цагаар хувийн асуудал хөөцөлдөх

б) Тусгай хэм хэмжээ

Удирдах ажилтан

- 2.3.11. Боловсролын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд идэвх санаачилгатай, бүтээлч, хариуцлагатай оролцох
- 2.3.12. Сургууль, бүрэлдэхүүн сургууль, нэгжийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, бодлого боловсруулах чадвартай байж, түүний хэрэгжилт, явц, үр дүнд анхаарч ажиллах
- 2.3.13. Удирдах арга барил, хууль эрх зүй, менежментийн мэдлэг, чадвараа байнга дээшлүүлж, сургуулийн хөгжил цэцэглэлтэд бодитой хувь нэмэр оруулах
- 2.3.14. Сургалт, эрдэм шинжилгээний түвшин орчин үеийн хөгжлийн шаардлага, шинжлэх ухаанч академик чиг хандлагатай нийцүүлэн шинэчилж байх
- 2.3.15. Сургуулийн багш, ажилтан, ажилчин, суралцагчдын идэвх санаачилгыг өрнүүлж, бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх
- 2.3.16. Сургуулийн амьдралтай холбоотой мэдээллийг хамт олонд ил тод нээлттэй байлгах
- 2.3.17. Аливаа шийдвэрийг сургууль, хамт олны эрх ашгийн үүднээс ухаалаг, зүй зохистой, үндэслэлтэй гаргах, шийдвэрийн үр дүнд хяналт тавих;
- 2.3.18. Аливаа сонгон шалгаруулалт, боловсон хүчнийг сонгох, дэвшүүлэхэд өөрийн хамаатан садан, хувийн ойр дотно харилцаатай найз нөхдийг дэмжих, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх
- 2.3.19. Хувийн болон хамаатан садан, ойр дотно харилцаатай хүмүүст бизнесийн шууд ба шууд бус ашиг олгох боломжийг бүрдүүлэхгүй байх

**Гурав. Ёс зүйн зөрчил, гомдлыг шийдвэрлэх,
Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам**

3.1. Ёс зүйн зөвлөл

3.1.1. ОУУБИС нь багшийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчил гаргасан талаарх асуудлыг шалгаж, хариуцлага хүлээлгэх үндэстэй эсэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ёс зүйн зөвлөлтэй /цаашид "Зөвлөл" гэх/ байна.

3.1.2. Зөвлөл үйл ажиллагаандаа шударга, тэгш хандах, нууцыг хадгалах, хараат бус байх зарчмыг баримтална..

3.1.3. Зөвлөл нь дарга, гишүүд, нарийн бичиг гэсэн байгууллагын төлөөлөл бүхий орон тооны бус 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.1.4. Зөвлөлийн гишүүнийг бүрэлдэхүүн сургууль, нэгж, хамт олны хурлаас олонхын саналаар сонгож, Ерөнхий захирлын тушаалаар баталгаажуулна.

3.1.5. Зөвлөл нь багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах, санал, зөвлөмж өгөх, зөрчил дахин давтагдахгүй байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.1.6. Зөвлөл нь багш, удирдах болон бусад ажилтны ёс суртахууны харилцаатай холбоотой гомдол, хүсэлтийг хүлээн авч, учир шалтгааныг магадлан тогтоож, шийдэх арга замыг тодорхойлох, дүгнэлт гаргана.

3.1.6. Зөвлөлийн хурал нь ээлжит болон ээлжит бус байх бөгөөд хуралд хэлэлцсэн асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ.

3.1.7. Зөвлөлийн гишүүдийн ирц 70 хувь хүрсэн бол хурлыг хүчинтэйд тооцно.

3.1.7. Зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтөлж, зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

3.2. Гомдол, хүсэлт гаргах, хүлээн авч шийдвэрлэх ажиллагаа

3.2.1. Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд түүнд холбогдох нотлох баримтыг хавсаргаж болно.

3.2.2. Гомдол, хүсэлтийг зөрчил гаргаснаас хойш 2 сарын дотор гаргах бөгөөд шалгах үндэслэл байна гэж үзвэл зөвлөл хугацаа харгалзахгүйгээр хүлээн авч болно.

3.2.3. Зөвлөл гомдол, хүсэлтийг хүлээн авах үндэслэлгүй гэж үзвэл хүлээн авахаас татгалзаж болох бөгөөд энэ талаарх үндэслэлээ гомдол гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

3.2.4. Зөвлөлийн нарийн бичгийн дарга ёс зүйн асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэн Зөвлөлийн даргад танилцуулах бөгөөд

зөвлөлийн дарга зөвлөлийн гишүүдээс нэг ажилтныг шалгуулахаар томилж, өргөдөл, гомдлыг хүлээлгэнэ өгнө.

3.2.5. Ёс зүйн зөрчлийг хянан шалгах аар томилогдсон зөвлөлийн гишүүн 10 хоногийн дотор гомдол, хүсэлттэй холбоотой баримтыг цуглуулах, гомдолд холбогдогчид гомдлын талаар танилцуулах, тайлбар авах, бусад шаардлагатай арга хэмжээг авсны үндсэн дээр танилцуулга бичиж зөвлөлд танилцуулна.

3.2.6. Зөвлөл ёс зүйн талаар гаргасан гомдол, хүсэлтийг шалгах аар томилогдсон ажилтны шалгалтын материал, баримттай танилцаж, хэлэлцэж, ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар дүгнэлт, саналыг энэхүү дүрмийн 3.2.5-т заасан танилцуулгыг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор гаргана.

3.2.7. Зөвлөлөөс гаргасан дүгнэлт, саналыг ОУУБИС-ийн ерөнхий захиралд танилцуулна.

3.2.8. ОУУБИС-ийн ерөнхий захирал дүгнэлт, саналтай танилцаж, шийдвэр гаргана.

Дөрөв. Хариуцлага

4.1. Багш, ажилтан нь ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол холбогдох хууль тогтоомж, сургуулийн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу зохих хариуцлагыг хүлээлгэнэ.

4.2. Зөрчил гаргагчид зөрчлийн шинж байдал, хор уршгаас шалтгаалан дараах хариуцлага хүлээлгэнэ.

4.2.1. Анхааруулах

4.2.2. Амаар болон бичгээр сануулга өгөх

4.2.3. Амлалт авахуулах

4.2.4. Олны өмнө буруушаах

4.2.5. Албан тушаалын зэрэглэл бууруулах

4.2.6. Учирсан хохирлыг арилгуулах

4.2.7. ОУУБИС-ийн профессор, дэд профессор цолыг хүчингүй болгохыг тус сургуулийн эрдмийн зөвлөлд уламжлах

4.2.8. Хөдөлмөрийн гэрээг сунгахгүй байх

4.2.9. Хөдөлмөрийн хуульд заасан бусад арга хэмжээ